

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 24 оны 02 сарын 02 өдөр

№ SR-2024-01

Улаанбаатар хот

ХасБанк ХК-ийн Ногдол ашгийн бодлогод
нэмэлт өөрчлөлт оруулж, шинэчлэн батлах тухай

ХасБанк ХК ("Банк")-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хооронд явуулсан эчнээ санал хураалтаас гарсан шийдвэрийг үндэслэн:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Банкны Хувьцаа эзэмшигчид өмнө нь Банкны Ногдол ашгийн бодлогыг хэлэлцэж SR-2023-05 дугаартай тогтоолоор баталсан болохыг ("Ногдол ашгийн бодлого");
- Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") нь Ногдол ашгийн бодлогод тодорхой нэмэлт өөрчлөлт оруулахыг 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн R-2023-73 дугаар тогтоолоороо зөвлөмж болгосныг; мөн
- Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-өөс зөвлөмж болгосны дагуу Ногдол ашгийн бодлогыг батлахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Дээрхийг үндэслэн, Ногдол ашгийн бодлогын 3.1 бслон 3.2 дахь хэсгүүдэд дараах байдлаар нэмэлт өөрчлөлт оруулсугай:

Одоогийн заалт	Нэмэлт өөрчлөлт оруулсан заалт
3.1. Банк нь өөрийн хөрөнгө, хөрвөх чадвар, зохицуулагч байгууллагын нөхцөл шаардлага, ирээдүйн ашиг орлого болон бусад эх үүсвэр, Банкны үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагааг цаашид өргөжин тэлэх боломж, эдийн засгийн болон санхүүгийн ерөнхий чиг хандлага, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах шаардлага зэрэг болон бусад олон хүчин зүйлийг харгалзан ногдол ашиг олгох эсэх талаар жил бүр шийдвэр гаргана.	3.1. Банк нь өөрийн хөрөнгө, хөрвөх чадвар, зохицуулагч байгууллагын нөхцөл шаардлага, ирээдүйн ашиг орлого болон бусад эх үүсвэр, Банкны үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагааг цаашид өргөжин тэлэх боломж, эдийн засгийн болон санхүүгийн ерөнхий чиг хандлага, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах шаардлага зэрэг болон бусад олон хүчин зүйлийг харгалзан ногдол ашиг олгох эсэх талаар хагас жил болон жил бүр шийдвэр гаргана.
3.2. Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Ногдол ашиг хуваарилах эсэхийг зарлах, ногдол ашиг	3.2. Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хагас жилийн ногдол ашиг хуваарилах эсэхийг оны

хуваарилах эзэмшигчдийн шийдвэрлэнэ.	шийдвэрийг хурлаар	Хувьцаа эцэслэн	эхний хагас жил дууссанаас хойш 120 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ. Ногдол ашиг хуваарилах эсэхийг зарлах, ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.
--	-----------------------	--------------------	---

2. Дээр дурдсан нэмэлт өөрчлөлт бүхий шинэчилсэн Ногдол ашгийн бодлогыг энэхүү тогтоолд хавсаргасан байдлаар баталсугай.
3. Энэхүү шийдвэрийг батлагдсан өдрөөс эхлэн тухайн асуудлыг зохицуулсан өмнөх бусад журмыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



2024 оны 02 сарын 02 өдөр

№ SR-2024-02

Улаанбаатар хот

2023 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас
ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, ХасБанк ХК ("Банк")-ийн Дүрмийн 8.6.(ii) дахь заалт болон Банкны Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн хооронд явуулсан эчнээ санал хураалтаас гарсан шийдвэрийг тус тус үндэслэн:

ТЭМДЭГЛЭХ нь:

- Банк нь 2023 оны эхний хагас жилийн байдлаар 61.7 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг 19.1%-д хүргэж ажилласан болохыг;
- Банкны Дүрэмд зааснаар ногдол ашиг хуваарилах асуудал нь стратегийн асуудал болохыг;
- Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") нь Банкны 2023 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг бэлэн мөнгөөр хуваарилах ("Хагас жилийн ногдол ашиг")-ыг хувьцаа эзэмшигчдэд санал болгосныг;
- Монголбанк нь 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А-1/1048 тоот албан бичгээрээ Банкинд хагас жилийн ногдол ашиг зарлан хуваарилахыг зөвшөөрсөн болохыг; мөн
- Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-өөс зөвлөмж болгосны дагуу Банкны Дүрмийн 8.6.(ii) дахь заалт болон Монголбанкны зөвшөөрлийг үндэслэн дор дурдсан дүнгээр Хагас жилийн ногдол ашгийг зарлан хуваарилахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

- Хагас жилийн ногдол ашигт нийт 15,527,325,000.00 (арван таван тэрбум таван зуун хорин долоон сая гурван зуун хорин таван мянга) төгрөг буюу нэгж хувьцаанд 14.75 (арван дөрвөн төгрөг далан таван мөнгө) төгрөг зарлан хуваарилсугай.
- Эчнээ санал хураалтад оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болох 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийг Хагас жилийн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.

3. Энэхүү шийдвэр батлагдсан өдрөөс хойш 7 хоногийн дотор Банкны ногдол ашгийг бэлэн мөнгөөр төлсүгэй. Хувьцаа эзэмшигч нь ХасБанкны дансаараа дамжуулан ногдол ашгаа авахаар бичгээр хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан ногдол ашгийг тараасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА